



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

62173 Арвайхээр, Өвөрхангай аймаг,
Утас/Факс: (976) 7032 3253,
E-mail: uvurkhangai@audit.gov.mn

2021.04.28. № 142.
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



О.БАТЖАРГАЛ



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2020 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Дансны ангилал кодыг анхаарах.....2

Тэргүүлэх ач холбогдол №2 зүйлс:

Асуудал 2

Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил
маш их илэрсэн.....3

Тэргүүлэх ач холбогдол №3 зүйлс:

Асуудал 3

Ажлын уялдаа холбоог сайжруулах, нэгдсэн чиглэл
заавраар хангах, Нягтлан бодогч нарын ажлыг үнэлж
дүгнэдэг, сургах, дадлагажуулах талаар.....3

2021 оны 04 дүгээр сар

Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг төсвийн ерөнхийлөн захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд ажлын уялдаа холбоог сайжруулах, зөрчлийг бууруулах, зөвлөн туслах, сургах дадлагажуулах, хяналт тавин ажиллах талаар 4 зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан байгууллагын нягтлан бодогч болон холбогдох бусад ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Ажил гүйлгээний ангилал кодыг төсвийн захирагч нар шат шатандаа анхаарах

Тэргүүлэх ач холбогдол №1

ТАГ-ын ажиглалт

Төсөвт байгууллагуудын хэрэглэж байгаа санхүүгийн программ хангамж, сангийн яамны Э-тайлантай төдийлөн уялдахгүй байгаагаас зарим дансны үлдэгдэл, болон ажил гүйлгээнүүд өөр өөр ангилал кодоор тайлагнагдаж байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.3. "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Эрсдэлүүд ТЕЗ-ийн санхүүгийн тайлан буруу тайлагнагдаж, хэрэглэгчдийг үнэн зөв мэдээллээр хангаж чадахгүй.

ТАГ-ын зөвлөмж

1.Шат шатны төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар ажил гүйлгээгээ бүртгэхдээ дансны ангилал кодыг СЯ-ны Э-тайлан болон НББ-ийн програмтайгаа уялдуулж бүртгэлээ хөтлөх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ТАГ-ын ажиглалт

2020 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн алдаа зөрчлөөс үзэхэд "Нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой зөрчил" дийлэнх хувийг эзэлж байна. Энэ нь: 1. Сүүлийн жилүүдэд нягтлан бодогч нарыг томилохдоо зохих хэмжээний боловсрол, дадлага туршлага, шалгуур, шаардлага харгалзахгүйгээр томилж ирсэн байна. 2. Нягтлан бодогч нар НББ-ийн программаа бүрэн эзэмшиж чадахгүй, НББ хөтлөх, дансны харьцаа хийх наад захын мэдлэг чадвар дутмаг, зөвхөн программ дээр гүйлгээг шивэх операторын түвшинд хязгаарлагдсан ня-бо нар олширчээ. 3. Нягтлан бодох бүртгэлийн стандарт, бодлого, хууль, журам, дүрмээ судалдаггүйтэй холбоотой байна.

Эрсдэлүүд НББ-ийн тухай хууль, болон стандарт зөрчигдөх

ТАГ-ын зөвлөмж

2. Нягтлан бодогч нарын мэдлэг чадварыг сайтар харгалзаж, тодорхой хэмжээний шалгуур шаардлага тавьж томилж байх.

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ТАГ-ын ажиглалт

1. Төсвийн төвлөрүүлэн захирагчдын аудитаас дүгнэхэд, удирдлага болон эрх бүхий дээд байгууллагаас тавьсан хяналт, ажлыг үнэлж дүгнэсэн байдал, заавар зөвлөмж, өгсөн зүйл төдийлөн байхгүй байсан. Иймээс сумдын төрийн сангууд болон нягтлан бодогч нарын ажлыг үнэлж дүгнэх, сургах, дадлагажуулах тал дээр учир дутагдалтай байна.

2. Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтсээс нягтлан бодогч болон сумдын төрийн сангуудыг нэгдсэн мэдээ, мэдээлэл, чиглэл заавраар тухай бүр хангаагүй, хоорондын ажлын уялдаа холбоо дутмаг байна.

ТАГ-ын зөвлөмж

1. Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтсээс нягтлан бодогчид болон сумдын төрийн сангуудыг нэгдсэн мэдээ, мэдээлэл, чиглэл заавраар тухай бүр хангаж, ажлын уялдаа холбоогоо сайжруулж ажиллах.

2. Сумдын төрийн сангуудын ажлыг үнэлж дүгнэдэг байх, нягтлан бодогч нарыг сургах дадлагажуулах, заавар зөвлөмж тухай бүр өгч байх.

Эрсдэлүүд Нягтлан бодогч
мэргэжлийн үнэ цэнэ буурах, санхүүгийн
сахилга бат алдагдах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил
дутагдлыг төсвийн захирагч хүлээн
зөвшөөрсөн болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ ХЯНАСАН
ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: О.БАТЖАРГАЛ
АУДИТЫН МЕНЕЖЕР: Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР:
АУДИТОР

Ц.Мөнхзаяа

Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ц.МӨНХЗАЯА

2021 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 25